

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ I УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТ

2026 оны 03 дугаар
сарын 24

Улаанбаатар
хот

Онцгой байдлын ерөнхий газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний I улирлын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын III хавсралтаар батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа үр дүнг үнэлж, дүгнэх журам” -ын дагуу хийв.

Онцгой байдлын ерөнхий газраас 2026 онд дэвшүүлсэн “Гамшгаас хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, байгууллагын үйл ажиллагааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, Алба хаагчдын бэлтгэл, бэлэн байдал, сахилга хариуцлага, ажлын үр дүн, бүтээмжийг дээшлүүлэх” үндсэн 2 зорилтын хүрээнд 74 арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр төлөвлөлтөд оролцогч 12 нэгжийн хэрэгжүүлсэн болон хамтран ажилласан, уялдааг хангасан байдлыг заагдсан хугацаа, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтэд уялдуулан шаардлагатай зарим асуудлыг холбогдох эрх бүхий албан тушаалтан, алба хаагчдаас тодруулах зарчмаар зорилт, нэгж тус бүрээр, өссөн дүнгээр гэсэн хэлбэрээр хяналт-шинжилгээ, үнэлгээг хийв.

Тайлант хугацаанд буюу I улиралд хэрэгжих 8, I-II улиралд хэрэгжих 3, I-III улиралд хэрэгжих 2, I-IV улиралд хэрэгжих 32 ажил арга хэмжээг тус бүрээр үнэлгээ хийж, хамтатган өссөн дүнгээр нийт 45 арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэв.

Үүнээс “Бүрэн хангалттай”, 45 ажил арга хэмжээ, “Хангалттай” 0 ажил, арга хэмжээ “Хангалтгүй” 5 ажил, арга хэмжээ буюу өссөн дүнгээр **91.5** хувийн үнэлгээтэй дүгнэгдсэн.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР